



## КОВИД-19 БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

### УДИРТГАЛ

Нээлттэй Нийгэм Форум, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоотой хамтран коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхүүдэд хэрхэн тусаж байгааг судлан, үр дүнг нь уг тайлангаар хүргэж

байна. Судалгаанд оролцсон хот, хөдөөгийн 90 гаруй өрх 2020 оны 4 дүгээр сарын байдлаар мэдээлэл өгсөн тул уг тайланд 5 дугаар сараас хэрэгжсэн татварын хөнгөлөлт, бэлэн мөнгөний дэмжлэгийн нөлөө тусаагүй болно.

### НӨХЦӨЛ БАЙДАЛ

2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн Улсын онцгой комиссын хурлаар 12 сарын сүүлээр улирлын амралт, үргэлжлээд томуугийн дэгдэлтийг таслан зогсоох зорилгоор түр завсарлаад байсан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл түр зогсоох, улмаар сургалтыг цахимаар явуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдад үүрэг болгожээ. Түүнчлэн сургууль, цэцэрлэгийг түр хаах хугацааг дахин 3 удаа сунгаж<sup>1</sup>, 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл танхимын сургалт хийхгүй байх шийдвэр хэрэгжиж байна.

2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт” (хэсэгчлэн)

шилжүүлж, байгууллагуудыг ажлын тусгай горимд шилжүүлэх, олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байх, баар цэнгээний газрын үйлчилгээний цагийг хязгаарлах зэрэг арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн.

Уг судалгаагаар дээрх шийдвэрт туссан хоёр асуудлыг онцлон авч үзлээ. Нэгдүгээрт, COVID-19-өөс урьдчилан сэргийлэх бодлогын хүрээнд тогтоосон хөл хорио, үйлчилгээний хязгаарлалт нь өрхийн орлого, зардалд хэрхэн нөлөөлж байгааг ойлгохыг зорив. Хоёрдугаарт, төрийн үйлчилгээг цахим болон зайны хэлбэрт шуурхай шилжүүлсэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлд хэрхэн нөлөөлснийг баримтжуулахыг оролдов. 2019-2020 оны хичээлийн жил бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамруулан сургаж эхэлсэн анхны жил тул боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг бүх нийтийн зайны боловсролд хэрхэн хамруулж буйг баримтжуулах асуудлыг энд багтаан авч үзлээ.

<sup>1</sup> Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг Улсын онцгой комиссын 1 дүгээр сарын 24-ний шийдвэрээр 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл, Засгийн Газрын 64 дүгээр тогтоолоор 3 дугаар сарын 30-ны өдөр хүртэл, Засгийн газрын 102 дугаар тогтоолоор 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл, Засгийн газрын 139 дүгээр тогтоолоор 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл тус тус хойшлуулжээ.

# 1. ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЭХ ҮЕИЙН ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

## ӨРХИЙН ОРЛОГО

Судалгааны энэ асуултад тодорхой хариулт өгсөн 76 өрхөөс коронавирусын халдвар тархахаас сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын үеэр 65 өрхийн орлого буурч, 11 өрхийн орлогод сөрөг нөлөө үүсээгүй байна.

Энэ хугацаанд 13 хүн ажилгүй болж, 3 хүний ажил түр зогсоод байгаа бол 3 хүний ажлын цаг багассаны улмаас цалин буурч, нэмэгдлүүд хасагджээ. Шалтгаанаар нь бүлэглэх юм бол цомхотголын улмаас хамгийн олон буюу 9 хүн орлогогүй болсны дотор эхнэр, нөхөр хоёул, мөн өрхдөө ганцаараа ажил хийдэг хүн хэд хэд байна. Эрэлт буурсан шалтгаанаар гэрээрээ орчуулга, оёдол зэрэг үйлчилгээ эрхэлж байсан 3, байгууллага нь түр зогсолт хийсэн 3, ажлын цаг нь богиноссон 3 гээд нийт 9 хүний орлого зогссон, буурсан байдалтай байна. Хүүхдээ харж, хичээлийг нь хийлгэхээр ажлаасаа түр чөлөө авсан, эсвэл хувиараа хийдэг ажлаа хойш тавиад байгаа 4 хүн байна. Хөдөлмөрийн гэрээ байгуулалгүй хувь хүнд хөлсөөр ажиллаж байсан хүн 1-3 дугаар сард ажлын хөлсөө авч чадаагүй нь уг судалгааны

хүрээнд илэрсэн хамгийн урт хугацааны орлого алдагдлын тохиолдол болов.

Богино хугацаатай хөдөлмөрийн гэрээтэй, эсвэл цагаар гэрээгүй ажилладаг, гэрээсээ захиалга авч хувиараа ажил, үйлчилгээ эрхэлдэг, цомхотголд өртсөн, хүүхдээ харах хэрэгцээтэй хүмүүсийн орлого зогссон, буурсан байна.

### ХЭНИЙ ОРЛОГО ӨӨРЧЛӨГДӨӨГҮЙ ВЭ?

Судалгаанд хамрагдсан 76 өрхөөс 11 өрхийн орлого өөрчлөгдөөгүй байна. Нэмэлт тайлбар өгсөн 2 өрхийн хувьд эхнэр нь хэвийн ажиллаж байгаа тул цалин буураагүй, нөхөр нь халамжийн тэтгэмж авдаг тул мөн хэвийн орлоготой байгаа ажээ. Нөгөө өрхийн эхнэр нь хүүхдээ төрсөн цагаас нь гэрээрээ асарч ажил хийхгүй байгаа тул орлого бүрдүүлэхэд оролцохгүй, нөхөр нь онлайн горимоор ажиллан цалингаа бүтэн авч байна.

Өндөржүүлсэн бэлэн байдлын энэ үеэр онлайн горимд ажлаа шилжүүлэх боломжтой, мөн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авдаг хүмүүсийн орлого өөрчлөгдөөгүй байна.

## ӨРХИЙН ЗАРДАЛ

Өрхийн зардлын судалгаанд хамрагдсан 65 хүн тодорхой хариулт өгснөөс 57 өрхийн зардал их, бага хэмжээгээр нэмэгдэж, 8 өрхийн зардал өөрчлөгдөөгүй байна.

Өрхийн зардал нэмэгдсэн нь байнга гэртээ байгаа өрхийн гишүүдийн хүнс болон ахуйн хэрэглээ өсөхтэй зэрэгцээд юмны үнэ нэмэгдсэнээр тайлбарлажээ. “Цалингийн хэмжээ буураагүй байтал өдөр тутмын амьдралд хүрэлцэхгүй болж байна” гэж судалгаанд оролцогч онцолжээ.

### ЯМАР ЗАРДАЛ НЭМЭГДСЭН БЭ?

Нэмэлт тайлбар өгсөн оролцогчид хоол хүнсний зардал, цахилгаан, ус, кабель, түлш зэрэг ахуйн хэрэглээний зардал, мөн интернэтийн зардал өссөнийг онцолжээ.

Хөл хорионы үеэр ихэнх өрх хүнсэндээ илүү мөнгө зарцуулдаг болжээ. Хүүхдүүд сургууль, цэцэрлэг дээрээ долоо хоногийн таван өдөр завгүй байхын зэрэгцээ цэцэрлэгийн хоол, сургуулийн үдийн

цай, өөрөө худалдаж авсан хоол, хүнсний зүйл хэрэглэдэг. Одоо өрхүүд гадуур хооллохгүй байгаа тул дэлгүүрээс худалдаж авах хоол, хүнсний хэмжээ нэмэгджээ. Мөн гэрээс гарахгүй, нийгмийн харилцаа нь хязгаарлагдан, уур бухимдалтай болж байгаа хүүхдээ тайвшруулах, уйдаахгүй байх зорилгоор хоол их хийж, амттан авч өгч байгаа ажээ.

Гэртээ байнга хүнтэй байгаа болохоор өрхийн цахилгаан, ус, түлш, кабель, интернэтийн зардал өссөн байна. Хүүхдүүдийн интернэтийн хэрэглээ

нэмэгдэж, төлбөр нь “өрхийн эдийн засагт нөлөөлөх” хэмжээнд хүрсэн тухай нэг оролцогч онцолжээ.


### ӨРХҮҮД ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВЧ БАЙНА ВЭ?

Өрхийн орлого нэмэгдээгүй боловч зардал өсөж байгаа энэ үед “... сардаа гардаг зардлаа нэмэгдүүлэхгүйн тулд хэмнэлт хийж” байгаа ажээ. Таван оролцогч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдээ витамин, нэмэлт тэжээл, эм тариа, живх авч өгч чадахгүй байгаадаа маш их санаа зовж байна гэж хариулжээ.


## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### ОРЛОГОО АЛДАХ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ Ч ОРЛОГО ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНД БАГТАЖ ЧАДАХГҮЙ ХҮМҮҮСИЙГ ХЭРХЭН ХАМГААЛАХ ВЭ?

ОРЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ, 2020 ОНЫ 4 САР



ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ, 2020 ОНЫ 4 САР



COVID-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шийдэмгий алхмуудыг цаг алдалгүй авч хэрэгжүүлж байгаа нь халдвар дотооддоо тархахаас амжилттай хамгаалж байна. 2020 оны 4 сарын 4-ний өдөр УИХ-аас “Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай” тогтоол баталж, 5 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн. Уг тогтоолоор нийт хөдөлмөр эрхлэгчдийн 75 орчим хувийг бүрдүүлж байгаа 39.0 мянган ажил олгогч, тэдний ажилтан 705.0 мянган хүн,

мөн сайн дураар нийгмийн даатгал төлж байгаа 121.0 мянган хүн 6 сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөж<sup>2</sup> байгаа нь иргэдийн орлогыг хамгаалах бодит алхам болж байна. Уг тогтоолоор мөн орлого нь өмнөх жилийн мөн үеэс 50 хувиар буурсан ч ажлын байраа хадгалж байгаа аж ахуйн нэгжийн ажилтанд 6 сарын хугацаанд 200.000 төгрөгийн дэмжлэг олгох арга хэмжээ багтсан. Одоогоор хэдэн хүнд өгөх тооцоо гараагүй байгаа ч ойролцоогоор 45,000 ААН хамрагдах тооцоо<sup>3</sup> байна.

<sup>2</sup> Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан ёсны вэбсайтад 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдөр нийтлэгдсэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэд дарга Т.Батмөнхийн өгсөн ярилцлага. <http://www.ndaatgal.mn/v1/view/1410>


<sup>3</sup> Эх сурвалж: «Орлого нь 50 хувь буурсан ч ажлын байраа хадгалж байгаа ААН-ийн ажилтнуудад 200,000 төгрөг олгоно» мэдээ. <https://ikon.mn/n/1ujv>

Дээрх хоёр шийдвэр нь манай судалгаанд оролцсон түр ажилгүй болсон, ажлын цаг нь багассан 4 хүнд шууд дэмжлэг болно. Харамсалтай нь, орон тооны цомхотголд орсон 10 хүн ямар нэг дэмжлэг авч чадахгүй, орлогогүй хоцрох өндөр эрсдэлтэй байна.

Цар тахлаас сэргийлэх энэ цаг үеэр орлогогүй болох хамгийн өндөр эрсдэлтэй хүмүүс бол тогтмол ажлын байргүй, тогтвортой хөдөлмөрийн гэрээгүй хүмүүс бөгөөд тэдний хөдөлмөрийн харилцааг “албан бус сектор” гэж тооцон, бодлогын арга хэмжээнээс хасах хандлага дэлхий нийтэд давамгайлдаг. Ийм өндөр эрсдэлт бүлэгт богино хугацаат гэрээтэй, эсвэл огт хөдөлмөрийн гэрээгүй аман тохиролцоогоор, цагаар, нэг удаагийн ажлаар орлогоо бүрдүүлдэг хүмүүс, мөн өөртөө ажлын байр гаргаж гэрээсээ ажил, үйлчилгээ эрхэлдэг хүмүүс орж байна.

Хоол хүргэх, дуудлагын таксигаар үйлчлэх, айлын гэр цэвэрлэх, хүүхэд харах, гэр нүүлгэх, захиалгаар юм оёх, хувиараа тавилга засах, гэрээрээ орчуулга хийх зэрэг хөдөлмөрийн гэрээгүй ажил хөдөлмөр эрхэлж байсан хүмүүс цар тахлын үеэр орлогогүй болж байгаа тухайд олон оронд шуурхай шийдэл хайж байна. Хөдөлмөрийн гэрээгүй ажилчин гэсэн шинэ ангилал гаргаж бүртгэн, яаралтай нийгмийн хамгаалалд хамруулах, эсвэл зөвхөн энэ цаг үед хамаатай түр бүртгэл хийж орлого нөхөх мөнгөн дэмжлэг үзүүлэх гэсэн хувилбаруудыг судалж байна.<sup>4</sup>

Монгол Улсад шинээр хөтөлбөр бий болгохоос илүүтэй одоо амжилттай хэрэгжиж байгаа дараах 3 хөтөлбөрийг өргөжүүлэх замаар асуудлыг тодорхой хэмжээнд зохицуулах боломж байна. Үүнд:



### Ажилгүйдлийн

Цомхотголд орсон ажилтан Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдах боломжтой ч энэ дэмжлэгийг анх удаа авахын

### тэтгэмж:

тулд 24 сараас багагүй хугацаанд ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн байх, үүнээс сүүлийн 9 сард тасралтгүй төлсөн байх шаардлагатай бөгөөд ажлаас халагдсан тушаалаа авчрах шаардлагатай. Цар тахлаас сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын энэ үеэр ажилгүйдлийн тэтгэмжийн хамрах хүрээг тэлж, цагийн болон түр ажил, гэрээр болон хувиараа хөдөлмөр эрхэлж байсан хүмүүсийг хамруулах боломжийг судлах хэрэгтэй юм. Илрүүлэх, бүртгэх, нотлох гээд амаргүй олон асуудал тулгарах ч онцгой цаг үед онцгой арга хэмжээ хэрэгтэй болдог.



### Хүнсний талон олгох хөтөлбөр:

Орлогогүй, бага орлоготой өрхийн бүртгэлийг шуурхай шинэчлэн, орлого нь тасарсны улмаас ядуурал руу гулгаж буй өрхүүдийг нэмж илрүүлэн, насанд хүрэгчид 16,0 мянган төгрөг, 0-16 насны хүүхдэд 8,0 мянган төгрөгийн (5 дугаар сараас 2 дахин нэмэгдэж байгаа) хүнсний эрхийн талон олгох боломжийг судалцаая.



### Цэцэрлэг, сургуульд сурч байсан хүүхдүүд бүгд хүнсний дэмжлэг

авч байсан бөгөөд үүнийг улсын төсвөөс санхүүжүүлдэг. 2019 онд сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” хөтөлбөр болгон өргөжүүлж, 2020 оноос бага ангийнхан, 2021 оноос дунд ангийнхан, 2022 оноос ахлах ангийнхныг хамруулах хууль 2019 онд баталсан. 2020 оны улсын төсөвт “Хүүхдийн үдийн цай” хөтөлбөрт 54.1 тэрбум төгрөг тусжээ. Мөн 2020 оны улсын төсөвт сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 30.1 тэрбум төгрөг, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 90.2 тэрбум төлөвлөжээ.<sup>5</sup> Сургууль, цэцэрлэгээр дамжуулан хүүхдийн хоол хүнсэнд зарцуулахаар төлөвлөсөн 174.4 тэрбум төгрөгийн сургууль, цэцэрлэг, дотуур байр ажиллахгүй байгаа энэ үед оногдох хэсгийг өрхөөр нь дамжуулан хүргэж болох юм.

<sup>4</sup> Эх сурвалж: <https://www.inlinepolicy.com/blog/covid19-gig-economy>

<sup>5</sup> Эх сурвалж: Сангийн Яам. Иргэдийн төсөв. <http://www.iltod.gov.mn/?p=4694в> 2020.02.05

## 2. ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЭХ ҮЕИЙН НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Судалгаанд оролцсон 89 өрхөөс 28 нь одоогийн нөхцөлд халамж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой ноцтой хүндрэлтэй тулгараагүй, хэвийн хамрагдаад явж байгаа ажээ. Хөл хорио тогтоосны улмаас төрийн зарим үйлчилгээ цахимаар материал бүрдүүлэх хэлбэрт шилжсэн нь үйлчлүүлэгчдэд илүү амар болсон байна. Цахимаар халамжийн материал бүрдүүлж шийдвэр гаргуулах ажлыг ойлгомжтой, чирэгдэлгүй зохион байгуулсан Ховд аймгийн туршлагыг иргэд магтжээ. Харин тулгарсан тодорхой хүндрэл бэрхшээлийг тоймлон танилцуулья.



### Халамжийн үйлчилгээтэй

холбоотой 11 шүүмжлэл гарсан байна. Халамжийн тэтгэмж, мөнгө авах эрхээ жил бүр сунгуулах ёстой бөгөөд сунгах шийдвэрийг Хөдөлмөр, эмнэлгийн магадлах комисс (зарим оролцогч Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комисс гэжээ)-ийн сард нэг удаа хуралддаг хурлаар гаргадаг. Цар тахлаас урьдчилан сэргийлэх ажил эхэлснээс хойш Комисс хугацаандаа хуралдахгүй хойшлох, хугацаагаа өөрчилсөн тухайгаа мэдэгдээгүйгээс хурлаар орж чадаагүйн улмаас 3 өрх тэтгэмжээ авч чадахгүй 1-2 сар өнжсөн байна. Мөн “санхүүжилт дууссан” гэсэн шалтгаанаар халамжийн тэтгэмжийг нэг сар алгассан явдал гарсан байна.

### Боловсролын үйлчилгээ

хамгийн их шүүмжлэл дагуулжээ. Шинэ нөхцөлд ТВ хичээлийн чанар, хүртээмж муу байгаа тул “боловсролын асуудал орхигдож байна”, “маш хүнд асуудал болж байна”, “сурлагын хоцрогдол үүсэж байна” гэж оролцогчид онцолжээ. ТВ хичээл зааж байгаа багшийн хурдыг гүйцэхгүй тул ойлгохгүй байгаа тухай шүүмжлэл хамгийн олон байна. Сургууль, багш нь хүүхэд, эцэг эхтэй холбоо тасалдаж, эцэг эх нь санаачилга гаргахгүй бол ангийн багш асууж сурагладаггүй байдал нийтлэг байгаа ажээ. Тэр

тусмаа боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийг тохирох хэрэглэгдэхүүн, нэмэлт дэмжлэгээр хангаж, эцэг, эхэд хүүхэдтэйгээ ажиллах мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч байхыг сургууль, багш нараас хүсэж байна. Хүүхэд хөгжүүлэх хичээлийн бус цагийн нэмэлт сургалт, заслын үйлчилгээ бүгд зогссон нь хүүхдийн ерөнхий хөгжилд сөргөөр нөлөөлөх вий гэсэн зовнил эцэг эхчүүдийн дунд өсжээ.



### Эрүүл мэндийн үйлчилгээ

авахад илүү хүндрэлтэй болсон гэж оролцогчид үнэлжээ. Шүдний эмчид үзүүлэх, улирал бүрийн хяналтын үзлэгтээ орох хэрэгцээ байгаа ч хүүхдээ эмнэлэгт авч очихгүй байгаа бөгөөд товлोलт үзлэгт ороогүй нь хүүхдийн тэтгэмжийг сунгуулахад саад болох вий гэсэн айдатай байгаагаа хуваалцжээ. Гадаад нислэг зогссоны улмаас байнга уудаг уналт таталтын эм тасарсан, үнэ нь нэмэгдсэн тухай мэдээлжээ.

Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар оролцогчид маш олон санал шүүмжлэл хэлсний багагүй хэсэг нь өндөржүүлсэн бэлэн байдалтай холбоогүй, ер нь эдгээр үйлчилгээг авахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхөд тулгардаг асуудлуудыг хөндсөн байв.

### ТВ ХИЧЭЭЛИЙН ЧАНАР, ХҮРТЭЭМЖ



2019 оны намар тэгш хамруулан сургах боловсролын бодлого хэрэгжиж эхэлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд орон нутгийн сургуульдаа элсэн суралцаж эхэлсэн. Харамсалтай нь, 9-12 сард 4 сар хичээллэн Яам, орон нутаг, сургууль, багш, эцэг эх, хүүхдүүд дөнгөж учраа олж эхэлж байтал сургууль түр завсарлав. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд зайны боловсролд хамрагдан, ирэх намар ангийнхаа хүүхдүүдийн хамтаар анги дэвшин суралцах ёстой. Тэд өнөөдөр



ТВ хичээлдээ хамрагдан, амжилттай суралцаж чадаж байна уу?

### ТВ хичээл хэр хүртээмжтэй байна вэ?



Сургуулийн насны 86 хүүхдээс 9 нь ТВ хичээлээр амжилттай суралцаж байна. 77 хүүхэд ТВ хичээлээр суралцаж чадахгүй байгаагаас 68 нь огт үзэхгүй, эсвэл үзсэн ч ойлгохгүй; 6 нь хааяа үздэг; 3 нь ТВ хичээлийг ашиглахгүй, тусгай сургуулийн багшаас ганцаарчилсан даалгавар авч суралцаж байна.

### Хүртээмжгүй байгаагийн шалтгааныг хэрхэн тайлбарлах вэ?



ТВ хичээл хэтэрхий хурдан байна гэж олон хүн шүүмжилжээ. Мэргэжил арга зүйн хувьд багшийн яриа хэт хурдан байгаагаас гадна бодох цаг, боломж байхгүй, давтаж хэлэхгүй байгаа зэргийг нэрлэсэн ч эдгээр нь ТВ хичээлд ашиглах боломжгүй танхимын сургалтын онцлог байх гэж таамагласан байна. ТВ хичээлийг сонирхохгүй байгаа нь тоо бодох арга нь өөр тул ойлгохгүй, үзчихсэн сэдэв нь давтагдсан, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог зэрэг шалтгаан ч цухас дурдагджээ.

ТВ-ээр хичээлийн хүртээмжийг хязгаарласан зохион байгуулалтын хоёр асуудал хөндөгджээ. Дохионы хэлний орчуулга нь ойлгомжгүй, хэт жижиг дэлгэцтэй тул харагдахгүй байгаа нь сонсголын бэрхшээлтэй сурагчдад томоохон саад болж байна. Нэг өрхийн сургуулийн насны хүүхдүүдийн хичээлийн хуваарь давхцаад, зарим нь хичээлээ “таслах” явдал гарч байна.

### Боловсролын тусгай хэрэгцээг нь хэрхэн хангах вэ?



ТВ хичээл нь хүүхдийн боловсролын тусгай хэрэгцээг хангаж чадахгүй, улмаар хүүхэд нь сурлагаар хоцорч байгаад эцэг эх, асран хамгаалагчид их санаа зовж байгаа ч мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэгээр хангаж байгаа сургууль, багш тун цөөн

байна. 17 хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч нь ТВ хичээлтэй холбоотой зөвлөгөө авч байгаа бөгөөд 13 нь ангийн багшаас чат, утсаар долоо хоног бүр зөвлөгөө, нэмэлт даалгавар авч; 2 нь Насан туршийн боловсролын төв, 1 нь ТББ-ын мэргэжилтнээс асууж байгаа бол 1 хүн Сүлд ТВ-ээр гарч байгаа тусгай хэрэгцээт боловсролын хичээлийг үзэж байна.

69

хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нь мэргэжлийн ямар нэг дэмжлэггүй байна.

7

хүн энэ асуултад хариулж мэдэхгүй байгаа ба 2 хүүхэд сургуулийн насанд хүрээгүй гэжээ.

### Хүүхдийнхээ хичээлд тусалж байгаагаа эцэг эх, асран хамгаалагчид хэрхэн үнэлж байна вэ?



80 хүн хүүхдийнхээ хичээл сурлагад хэр тусалж байгаагаа үнэлжээ. Үүнээс, 16 хүн хүүхдэдээ тусалж чадаж байгаа, 19 хүн чадахгүй байгаа, давхардсан тоогоор 50 хүн бусдаас дэмжлэг авч байгаа гэжээ. Сонирхуулахад, зайны сургалтад багшийн оролцоог эцэг эхчүүд хоёр янзаар харж байгаа ба “өөрөө хичээлийг нь хийлгээд, мэдэхгүй зүйлээ багшаас асуудаг” гэсэн хэсэг хүн байхад “хүүхдийнхээ хичээлийг хийлгэж чадахгүй байгаа тул багшаас асуудаг” хэмээн эцэг эхийн хариуцах асуудал гэж үзэх хандлага илэрсэн юм.

Бусад хүний дэмжлэг авч байгаа 50 хүн байгаагаас хүүхдийн багш (23 хүн), эцэг, эх өөрсдөө (22), ах, эгч (2), тэтгэвэрт гарсан багш эмээ (1), багш мэргэжилтэй нагац эгч (1), багш хийдэг ээжийн найз (1), Фейсбүүк дэх ээжүүдийн групп (1), ТББ (1) зэрэг эх сурвалжийг ашиглаж байна. Багштай утсаар болон чатаар харилцдаг бөгөөд хариу авч чадахгүй тохиолдол гарах нь бий. Эцэг эх, асран хамгаалагч нь өөрөө ажиллаж байгаа тохиолдолд

ТВ хичээлийг хамт сууж үзэн тайлбарлах (туслах багшийн үүргээр оролцох), өөрөө эхлээд үзчихээд, дараа нь хүүхдэдээ заах (багшийг орлох), багшаас асууж байгаад хүүхдэдээ заах, эсвэл мэдэхгүй зүйл гарвал багшаас асуух (багштай хамтран ажиллах), мөн ТВ хичээлийг огт ашиглахгүй өөрсдөө тусгай хөтөлбөрөөр сургах зэргээр зохион байгуулж байна. Нэлээд олон оролцогч “өөрөө ойлгож байгаа ч хүүхдэдээ яаж заахаа мэдэхгүй байна”, “өөрийн сурсан аргаар л зааж байгаа ч сайн

ойлгуулж чадахгүй байна”, “сайн ойлгуулж чадахгүй байна” зэргээр хариулснаас харахад багш мэргэжлийн хүнээс арга зүйн дэмжлэг авах хэрэгцээ өндөр байна. Гэтэл зарим эцэг эх хаанаас мэдээлэл авах, багштай харилцаж болох эсэх тухай мэдэхгүй, “хөл хорионд байгаа болохоор гадуур явж сураглаж чадахгүй”, мөн брайль үсэг мэдэхгүй тул тусгай сургуулийн хүүхдэдээ тусалж чадахгүй байгаа гэжээ.

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах бодлого албан ёсоор орон даяар хэрэгжиж эхлээд 4 сар болж байтал цар тахлын улмаас сургууль зайны сургалтад шилжсэн. ТВ хичээлийн тухайд тэгш хамруулах сургах үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой хэд хэдэн хэрэгцээ илэрлээ. Эдгээр нь Монгол Улс даяар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ангидаа элсүүлэн сургаж байгаа багш нарт нийтлэгээр тулгарч буй арга зүйн хүндрэл байх магадлалтай тул ирэх хичээлийн жилд эдгээр багшид туслах арга зүйг хөгжүүлэх үндэс болох сайн талтай. Эдгээр хэрэгцээг дурдвал:

- Нэгж хичээлийн хугацааг сунгах, багш илүү интерактив, сурагчдын оролцоог хангасан заах арга зүй ашиглах;

- Үндсэн багш, туслах багштай эн зэрэгцэн хүүхэдтэй тулж ажиллаж байгаа эцэг эх, асран хамгаалагчдад хичээлийн явц, хүүхдийн оролцоог тогтмол мэдээлж, гэртээ хичээл давтуулахад ашиглах заах арга зүйн зөвлөгөө өгч байх;
- Ангийн багш, бусад хичээлийн багштай холбоотой байх, зөвлөгөө авах асуудлыг системчлэх, эцэг эхчүүдэд албан ёсоор мэдээлэх;
- ТВ болон зайны бусад хичээлийн дохионы хэлний чанар, хүртээмжийг сайжруулах;
- Тусгай сургуулийн багш нарыг ТВ хичээлд татан оролцуулах, хараа, сонсгол, оюуны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуульд ашигладаг арга зүйг танилцуулах, хүүхдийн эцэг эхтэй байнгын холбоотой байхад туслах зэрэг болно.

### 3. ЭЦЭГ ЭХ, ХҮҮХДИЙН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

Анх удаа Монголын нийгэм бүхлээрээ хөл хорио, нийгэмшихүйн хязгаарлалтад орж, энэ байдал нь даруй хэдэн сар үргэлжилж байна. Энэ байдал хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 85 хүний 19-д нь ямар нэг хүндрэл бэрхшээл үүсгээгүй бол 66 хүний хувьд асуудал болоод байгаа ажээ.

Хөл хорионы улмаас гадаа гарч, ядаж л дэлгүүр орж болохгүй гэртээ байнга байх нь хүүхдүүдэд маш их стресс үүсгэж байна. Хүүхэд хямран (16 хүн), бухимдсаны улмаас сэтгэцэд нь өөрчлөлт гарч эмчийн зөвлөгөө авахад хүрсэн (3), байнга харилцдаг гэрийнхэндээ бухимдан уурлах болж (7), хүчил төрөгч дутагдаж нойргүйдэх зэрэг бие махбодын хямрал илрэн (2), өдрийн дэглэм алдагдаж (1) байна. Гадаа гарахгүй тул ТВ сериал, интернэт үзэж, сүүлдээ унтахгүй үзэх гээд донтох шинж тэмдэг илэрсэн 2 хүүхдийн тухай мэдээлэл байна. Байнга гэртээ байгаа болохоор хүүхдийн өдрийн дэглэм өөрчлөгдөж, хэзээ хамаагүй юм идэж хоолны донтой болж байгаа бас нэг тохиолдол гарав. Гадаа гарч болохгүй гэхээр сайн ойлгохгүй, буруу зүйл хийгээгүй байхад нь гаргахгүй байна гэж уурлаж бухимдах явдал нэлээд олон гэр

бүлд тохиолджээ. 2019 оны сүүлээс эмчилгээ хийлгэж сургуульдаа яваагүй 2 ч хүүхэд ангийнхаа хүүхдүүдтэй холбоогүй болж, сурлагаар хоцорсны улмаас хямарч байгаа ажээ.

Эцэг эхчүүд хүүхдэдээ санаа зовох, өөрсдөө ядрах нь давхцан, нэлээд бухимдалтай байгаа ч бухимдлаа тайлах арга зам олж харахгүй байна. Хүүхэд улам зожгирах (4 хүн), сурлага, нийгмийн хөгжлөөр хоцрох (4), хүүхэд дэлгэцээс хамааралтай болох (4), мөн хүүхдээ ганцаараа харж дийлэхгүй болж байгаад (3) санаа нь зовж байна. Өөрсдөд нь гарч байгаа өөрчлөлтийг тоймлох юм бол хүүхдээ тайвшруулж чадахгүй стрессдэх (5 хүн), хүүхдээ харах гэж чөлөө их авч байгаа нь ажлын байранд асуудал болох (3), хүүхэдтэйгээ ажиллахад нь зөвлөн дэмжих хүн байхгүй мухардах (2), хүүхдээсээ өөр асуудалд цаг зав гаргаж чадахгүй байгаадаа бухимдах (1) зэрэг нэрлэгджээ.

Уг судалгаа нь хүүхэд, эцэг эхчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох зорилго агуулаагүй бөгөөд зөвхөн эцэг эх, асран хамгаалагчдын өөрсдийн үнэлгээг нэгтгэн хүргэж байгаа болно.

#### СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгаанд хараа, сонсгол, хэл яриа болон оюуны бэрхшээл, хөдөлгөөний бэрхшээл, тархины саажилттай хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчид оролцсон бөгөөд тэд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Монголын Аутизмын Холбоо, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, Түгээмэл хөгжил төв, Сонсголгүй хүүхэдтэй

эцэг эхийн холбоо, Эпилепси холбоо, Эпилепси цахим нэгдлийн гишүүд юм. Оролцогчид нь Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Орхон, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг, Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Сонгино-Хайрхан, Хан-Уул дүүргийн оршин суугчид байна.

